ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ
(2023 он)

2023.12.15

<table>
<tr><th>№</th><th>Үйл ажиллагаа</th><th>№</th><th>Шалгуур үзүүлэлт</th><th>Зорилтот түвшин</th><th>Хүрсэн түвшин</th><th>Тайлбар</th></tr>
<tr><td colspan="7">Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх</td></tr>
<tr><td rowspan="6">1</td><td rowspan="6">Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт</td><td>1.1</td><td>Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:</td><td>Сувилахуйн алба төлөвлөгөөний дагуу онолын -11 ур чадварын - 8 чиглэлээр -60</td><td>Онолын 11 сургалт, ур чадвар- 8</td><td rowspan="6">• 2023 онд тус эмнэлэг нь 16 сэдвээр 22 удаагийн багц цагийн сургалтыг танхим/цахим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулж, нийт давхардсан тоогоор 2000 эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнг тасралтгүй сургалтад хамруулсан байна. Үүнд; Мэдрэл судлалын тасгаас “Толгойн өвдөлт: Эмнэлзүйн өвөрмөц хэлбэрүүд, оношилгоо, эмчилгээний асуудлууд” сэдвээр нийт 76 эмч нарыг, Сэргээн засах эмчилгээний тасгаас 3 удаа танхим хэлбэрээр нийт 156 эмч, мэргэжилтэнг, “Орчин үеийн физик эмчилгээ”-1,2 ба “Мэс заслын дараах сэргээн засах эмчилгээ” сэдвээр, Зүрх судас судлалын тасгаас “Зүрхний зонхилон тохиолдох хэм алдагдлын үеийн оношлогоо, эмчилгээ, яаралтай тусламж” сэдэвт сургалтыг 110 дотор, зүрх судасны эмч нарт, Хоол боловсруулах эмгэг судлалын тасгаас "Элэг, цөсний замын өмөнгийн оношлогоо, эмчилгээ " сэдвээр 162 эмчийг, Эм зүйн албанаас “АНТИБИОТИКИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ” сэдэвт, Мэс заслын тасгаас 3 удаа танхим хэлбэрээр нийт 300 эмч, мэргэжилтэнг,</td></tr>
<tr><td rowspan="4">Үүнээс</td><td>Ажлын байран дахь сургалт</td><td>20</td><td>Багц цагийн сургалт-22<br>чиглэл-24</td></tr>
<tr><td>Мэргэшүүлэх сургалт</td><td>3</td><td>нийт сургалт-3<br>чиглэл-12</td></tr>
<tr><td>Туршлага солилцох арга хэмжээ</td><td>10</td><td>УБ хот- 5 орон нутаг -8</td></tr>
<tr><td>Бусад</td><td></td><td>багц цагийн -1</td></tr>
<tr><td>1.2</td><td>Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:</td><td>500</td><td>Нийт багц цагт хамрагдсан-2000<br>Нийт мэргэшүүлэхд хамрагдсан-176</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамрагдсан сувилагч- 154 | Уушиг судаллын тасгаас “Уушгины бөглөрөлт эмгэгүүдийн ялган оношилгоо, эмчилгээ” сэдэвт 2 багц цагийн сургалтыг 121 эмчид, Нэгдсэн лабораторийн тасгаас 2 багц цагийн сургалтыг нийт 95 мэргэжилтэнг, Бөөр, дотоод шүүрлийн тасгаас нийт 133 эмч, эмгэг судлаач нарыг, Яаралтай тусламжийн тасгаас нийт 172 эмнэлгийн мэргэжилтнүүдийг, УХТЭ-ийн дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс хороо нь “Эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүйн хэм хэмжээ’’ сэдэвт сургалтыг нийт 100 гаруй эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан байна.<br>• Төгсөлтийн дараах үндсэн мэргэшил, төрөлжсөн мэргэжил олгох сургалтуудыг хийсэн. Нийт 170 эмч төгсөлтийн дараах үндсэн мэргэшил олгох сургалтанд хамрагдсан бөгөөд үүнээс 86 эмч (дотрын анагаах ухаан судлал-38, мэс засал судлал-18, дүрс оношлогоо судлал-15, мэдрэл судлал-9, эрчимт эмчилээ судлал) амжилттай дүүргэсэн. 2023 оны жилийн эцсийн байдлаар Үндсэн мэргэшлийн сургалтанд дотрын анагаах судлал-22 эмч, дүрс оношилгоо судлал- 31, мэс засал судлал-21,Яаралтай тусламж судлал-3, Эрчимт эмчилгээ судлал-3, Мэдрэл судлал-4 эмч нар суралцаж байна. Мөн төрөлжсөн мэргэжил олгох сургалт 2023 онд 2 удаа явуулсан бөгөөд үүнд 4 эмч Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдалаар төрөлжсөн мэргэжлийн |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | 250 | 1511 | |
| | | | Эрэгтэй албан хаагч | 250 | 819 | |
| | | | Удирдах албан тушаалтан | 30 | 35 | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 470 | 2225 | |
| | | 1.3 | Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал:<br>Нийт албан хаагчдад эзлэх хувь | 90-ээс дээш | 90-ээс дээш | |
| 2 | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт | 2.1 | Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо | 5 | 5 улс | |
| | | 2.2 | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо | 20 | хамрагдсан - 26 | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | 10 | 8 | |
| | | | Эрэгтэй албан хаагч | 10 | 1 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Удирдах албан тушаалтан | 1 | 1 | үнэмлэх гардан авч, 2 эмч одоогийн байдлаар суралцаж байна. |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | 19 | 7 | ● Сувилахуйн албанаас сувилагч тусгай мэргэжилтнүүдийг чадавхжуулах, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх онол болон дадлага сургалтыг 61 удаа зохион байгуулж сургалтанд давхардсан тоогоор 683 сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан байна. Ажлын байрны сургалтыг 8 чиглэлээр 19 удаа зохион байгуулж 154 сувилагч мэргэжилтэн хамрагдсан. Сувилахуйн мэргэшүүлэх сургалтад эхний хагас жилд- 4 сүүлийн хагас жилд -19 сувилагч /28 / мэргэжилтэн хамрагдсан. Туршлага солилцох арга хэмжээг улаанбаатар хотын 3 эмнэлэг, хөдөө орон нутгийн 5 байгууллагатай харилцан туршлага солилцсон байна.<br><br>● Гадаадын өндөр хөгжилтэй улс орнуудад төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх урт хугацааны сургалтанд нийт 5 улсад,13 мэргэжлийн чиглэлээр 16 эмч, 1 сувилагч, 1 рентген техникч нийт 17 эмнэлгийн мэргэжилтнүүд ганцаарчилсан болон багаар хамрагдан суралцсан. Үүнд: бөөрний мэс заслын чиглэлээр 2 эмч АНУ болон Япон улсад, нүдний пластик мэс заслын чиглэлээр 1 эмч Япон улсад, Бөөр судлал чиглэлээр 1 эмч АНУ, тархи нугасны хавдрын чиглэлээр 1 эмч БНСУ-д, хавдрын чиглэлээр 1 эмч Тайваньд, уушги судлал чиглэлээр 1 эмч БНСУ-д, Мэдрэлийн мэс заслын мэдээгүйжүүлгийн чиглэлээр 1 эмч Тайваньд, зүрхний мэдээгүйжүүлгийн чиглэлээр 1 эмч |
| | | 2.3 | Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь | 20-оос дээш | 16.4% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тайваньд, мэдрэлийн мэс засал чиглэлээр 1 эмч БНСУ-д, гар сарвууны мэс засал чиглэлээр 1 эмч БНСУ-д, Зүрхний судсан дотуурх оношилгоо эмчилгээний чиглэлээр 2 эмч, 1 сувилагч, 1 рентген техникч БНСУ-д, нүд судлал чиглэлээр 2 эмч БНХАУ-ын ӨМӨЗО-нд, ходоодны уян дурангийн чиглэлээр 1 эмч Япон улсад тус суралцсан байна.<br><br>● Гадаадын өндөр хөгжилтэй улс орнуудад богино хугацааны сургалт, эрдэм шинжилгээний олон улсын хурал, семинарт 17 улсад, 27 мэргэжлийн чиглэлээр нийт 76 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан. Үүнд: сэргээн засах эмчилгээ, дүрс оношилгоо, мэс засал, мэдрэлийн мэс засал, хавдар, интервеншл радиологи, ходоодны уян дуран, зүрхний ангиографи, цөмийн оношилгоо, зүрх судас судлал, ортопед, гэмтэл согог, эм зүй, уушги судлал, мэдээгүйжүүлэг судлал, толгой хүзүүний мэс засал, ангиографи, үе судлал, уламжлалт, мэдрэл судлал, яаралтай тусламж, дотоод шүүрэл, сувилахуй, уушги судлал, нүд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал, эмнэлгийн тусламж, үйлчилгээ чиглэлээр Франц, Япон, Казакстан, БНСУ, Дани, АНУ, Канад, Тайвань, БНХАУ, ӨМӨЗО, Нидерланд, Тайланд, Хонг-Конг, Итали, БНПортугал, Унгар, Австрали улсуудад богино хугацааны сургалт, олон улсын эрдэм шинжилгээний хурал, семинарт оролцсон байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ● Гадаадын өндөр хөгжилтэй улс орнуудад богино хугацааны сургалт, эрдэм шинжилгээний олон улсын хурал, семинарт 27 чиглэлээр 17 улсад 76 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан. Үүнд сэргээн засах эмчилгээ, дүрс оношилгоо, мэс засал, мэдрэлийн мэс засал, хавдар, интервеншл радиологи, ходоодны уян дуран, зүрхний ангиографи, цөмийн оношилгоо, зүрх судас судлал, ортопед, гэмтэл согог, эм зүй, уушги судлал, мэдээгүйжүүлэг судлал, толгой хүзүүний мэс засал, ангиографи, үе судлал, уламжлалт, мэдрэл судлал, яаралтай тусламж, дотоод шүүрэл, сувилахуй, уушги судлал, нүд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал, эмнэлгийн тусламж, үйлчилгээ чиглэлээр Франц, Япон, Казакстан, БНСУ, Дани, АНУ, Канад, Тайвань, БНХАУ, ӨМӨЗО, Нидерланд, Тайланд, Хонг-Конг, Итали, БНПортугал, Унгар, Австрали улсуудад богино хугацааны сургалт, олон улсын эрдэм шинжилгээний хурал, семинарт оролцсон байна. |
| 3 | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн | 3.1 | Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая,төг) | 3.000.000 | 6.330.000 | ● KOFIH төслийн хүрээнд 1 удаагийн эмч нарын тасралтгүй сургалтыг зохион байгуулсан. Үүнд Нэгдсэн лабораторийн тасаг Молекул биологийн аргаар хийгдэж байгаа шинжилгээ, нөхөн үржихүйн эрүүл мэндийн лабораторийн оношилгоо, эмнэлзүйн хэрэглээ нэртэй сургалт зохион байгуулсан.<br>● СА-4.190.000 “Хувь хүний хөгжил” сургалт 120 сувилагч, тусгай мэргэжилтэн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 3.2 | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь | 15-аас доош | 21,3% | ● Шинээр ажилд орсон 143 үүнээс шинээр төгсөж ажилд орсон 46, ажлаас гарсан 98 үүнээс тэтгэврийн эрх үүсэн ажлаас чөлөөлөгдсөн 7 ажилтан байна.<br>● 2023 онд 55 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны ажлын байрны зохицуулалт хийж, түр болон урт хугацаагаар сэлгүүлэн, шилжүүлэн ажиллуулсан. (Ерөнхий захирлын 2023 оны Б/10, Б/11, Б/18, Б/40, Б/42, Б/48, Б/49, Б/51, Б/52, Б/53, Б/80, Б/81, Б/82, Б/89, Б/94, Б/102, Б/110, Б/133, Б/158, Б/159, Б/160, Б/166, Б/169, Б/172, Б/177, Б/179, Б/180, Б/181, Б/182, Б/183, Б/186, Б/187, Б/192, Б/203, Б/253, Б/290, Б/291, Б/292, Б/318, Б/338, Б/339, Б/340, Б/347, Б/348, Б/349, Б/381, Б/386, Б/388, Б/389, Б/390 дугаар тушаал) |
| Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах | | | | | | |
| 4 | Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | 4.1 | Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт эзлэх хувь | 42.3% | 46,7% | ● Эмнэлгийн үндсэн ажилтнуудад олгосон цалин, нэмэгдэл, нөхөн олговор, урамшуулалын зардалд 13,719,616,604.9 төгрөгийг олгосон нь нийт зардлын 41,4%-ийг эзэлж байна. Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 1,757,851,739.21 төгрөг зарцуулсан нь нийт зардлын 5,3% хувийг эзэлж байна.<br>● 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн эмнэлгийн ажилтан, мэргэжилтний үндсэн цалинг 30%-иар нэмэгдүүлсэн.<br>● Засгийн газрын 2023 оны 240,241 дүгээр тогтоолын дагуу Эмнэлгийн захирлын 2023 оны 07 дугаар сарын 19-ний А/75 дугаар тушаалаар эмнэлгийн хэвийн үйл ажиллагааг хангаг ажилладаг эмнэлгийн туслах албан тушаалтны цалинг Засгийн газрын тогтоолоор батлагдсан цалингийн доод жишгээс 20%, эмнэлгийн төрийн үйлчилгээний эрүүл мэндийн ажилтны цалинг Засгийн газрын тогтоолоор батлагдсан цалингийн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | доод жишгээс 10%-иар тус тус нэмэгдүүлж шинэчлэн баталсан. |
| | | 4.2 | Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг) | 611,588.3 | 774,741.0 | ● Эмнэлгийн захирлын 2023 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн ажилтны хоолны олговрыг өдрийн 8000, унааны олговрыг 2000 төгрөг болгон нэмэгдүүлэн шинэчлэн баталсан. (Эмнэлгийн захирлын 2023 оны А/76 дугаар тушаал)<br>● Нийт 566 ажилтанд 774,741.0 мянган төгрөгийн унаа хоолны хөнгөлөлтийг олгосон. |
| 5 | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх | 5.1 | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж) | 90-ээс дээш | 94.5% | 2023 оны Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн судалгаанд нийт 1016 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдлаа. Нэгдүгээр улиралд-290, хоёрдугаар улиралд-245, гуравдугаар улиралд-265, дөрөвдүгээр улиралд-216 эмч, эмнэлгийн ажилчид тус тус хамрагдсан байна. Судалгааны дүн: Нийт судалгаанд хамрагдсан эмч, ажилчдын 43% нь “Бүрдсэн”, 51.5% нь “Дунд зэрэг” гэж хариулсан байна. Нийлбэр дүнгээр 94.5% байна. |
| 6 | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | 6.1 | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд) | 1-ээс дээш | 1 | ● 2023 оны нийт ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгийг 2023 оны 08-р сарын 01-нээс 2023оны 12 дугаар сарын 01-ний хооронд зохион байгуулав. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдвал зохих нийт 558 ажилтнаас 542 ажилтан буюу 97.1% хамрагдсан<br>- Лаборатор, багажийн шинжилгээ – 426 ажилтан<br>- Эмчийн үзлэгт - 407 ажилтан хамрагдсан<br>- 2023 оны 1 дүгээр сарын 02-оос 2023 оны 12 дугаар сарын 01-ний хүртэл 135 хүн шинээр ажилд орон эрүүл мэндийн хуудасны дагуу лаборатори болон багажийн шинжилгээ өгч нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт бүрэн хамрагдсан. |
| | | 6.2 | Албан хаагчдын хамрагдалт | 90-ээс дээш | 97.1% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ● **Зонхилон тохиолдож буй өвчин эмгэг**<br>**Хоол боловсруулах эрхтэн судлал**<br>1. Архаг вируст хепатит<br>2. Архаг гастрит<br>3. Ходоод улаан хоолойн сөөргөө<br>4. Ходоодны шархлаа<br>5. Ходоодны ургацаг<br>6. Цөсний хүүдийн архаг үрэвсэл<br>7. Нойр булчирхайн архаг үрэвсэл<br>**Зүрх судас**<br>1. Зүрхний даралт ихсэх өвчин<br>2. Таргалалт<br>3. Ишеми<br>4. Цээжний Бах<br>5. Хэм алдагдал<br>**Уушги судлал**<br>1. Астма<br>2. Архаг бронхит<br>**ДШбулчирхай**<br>1. Чихрийн шижин хэв шинж2<br>2. Бамбай булчирхайн зангилаа<br>**Бөөр судлал**<br>1. Шээс дамжуулах замын халдвар<br>2. Бөөрний дутагдал<br>**Мэдрэл судлал**<br>1. Бүсэлхий нурууны өвдөлт<br>**Үе судлал**<br>1. D аминдэмийн дутал<br>**Арьс судлал**<br>1. Атопит дерматит<br>2. Харшлын ринит<br>3. Хавьтал харшлын дерматит<br>4. Чонон хөрвөс<br>**Мэс засал**<br>1. Цөсний хүүдийн чулуужих өвчин<br>2. Цөсний хүүдий ургацаг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. Элэгний гемангиома<br>**Урологи**<br>1. Бөөрний уйланхай<br>**Эмэгтэйчүүд**<br>1. Умайн лейомиом<br>2. Өндгөвч, үр дамжуулах хоолой ба өргөн холбоосны үрэвсэлт бус эмгэг<br>**Нүд**<br>1. Глауком<br>2. Ойрын болон холын харааны өөрчлөлт<br>**ЧХХ**<br>1. Хамрын таславч муруйх<br>● **Эмнэлгийн ажилтнууд амбулатори болон стационарт** ХЧТА бүгд 266, хэвтэн эмчлүүлсэн 188.<br> |
| 7 | Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал | 7.1 | Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | 6,067.2 сая төгрөг | 6,067.2сая төгрөг | ● Эмнэлэг болон эмнэлгийн үйлдвэрчний эвлэлийн хорооны 2023-2026 оны “Хамтын гэрээ”-г 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр шинэчлэн байгуулсан.<br>● Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Нягтлан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бодох бүртгэлийн тухай хууль 22.1 дэх заалтын дагуу эмнэлгийн хэмжээнд Анагаах ухааны доктор 10, Зөвлөх эмч 12, Зөвлөх сувилагч 3, Тэргүүлэх эмч 38, Тэргүүлэх сувилагч 40, Ахлах эмч 35, Ахлах сувилагч 23, бусад мэргэжилтэн 9 нийт 170 ажилтанд боловсролын болон зэргийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10-20 хувиар тус тус тооцон 258,275,884.00 төгрөгийн нэмэгдэл олгосон.<br>● Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 151 дүгээр тогтоолын дагуу төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл нийт 479 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 557,350,703.00 төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон.<br>● Хөдөлмөрийн тухай хуулийн 108.1 дүгээр заалт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын дагуу хөдөлмөрийн хэвийн бус нөхцлийн нэмэгдэл 227,436,632.00 төгрөгийг 196 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон.<br>● Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн дагуу илүү цагаар болон 7 хоногийн амралт, нийтээр амрах баяр ёслолын өдөр ажиллуулсны хөлс болох 2,985,783,817 төгрөгийг давхардсан тоогоор нийт 4512 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон.<br>● Дуудагдан ажилласны хөлс болох 103,117,000.00 төгрөгийг давхардсан тоогоор нийт 885 эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанд олгосон. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ● Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72,1 дэх заалт, Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны А/59 дугаар тушаалын дагуу Шөнийн цагт ажилласны нэмэгдэл 148952 цагийн 148,952,000 төгрөг олгогдсон.<br>● Алсын болон төрөлжсөн мэргэжлийн дуудлагаар явж эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэний нэмэгдэл хөлсийг Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу нийт 8 эмнэлгийн мэргэжилтэн ажилтанд 368,586 төгрөг олгосон.<br>● Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтын дагуу хоол, унааны нэмэгдэл 774,741,000.00 төгрөгийг 549 ажилтанд олгосон.<br>● Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05, 395 дугаар тогтоолоор тус тус батлагдсан "Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшил олгох журам"-ын дагуу Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүрийн ажлын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу алба, тасгийн хамт олноор ил тодоор үнэлүүлдэг ба 2023 оны I улиралд 513 эмнэлгийн эрүүл мэндийн ажилтанд 254,541,184 төгрөг, II улиралд 504 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 273,498,056 төгрөг III улиралд 507 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд 267,966,658 төгрөг Нийт 796,005,898 төгрөг олгогдсон. (Эмнэлгийн ерөнхий захирлын 2023 оны А/41, А/70, А/105 тушаалууд)<br>● Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтад заасны дагуу ур чадварын нэмэгдлийг 27 ажилтанд 10%- |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иар тооцон нийт 33,525,936.00 төгрөг тооцон олгосон.<br>● Хариуцлагын нэмэгдлийг 63 ажилтанд нийт 104,017,998.00 төгрөг тооцон олгосон.<br>● Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хөдөлмөрийн чадвар алдсан өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл тахир дутуугийн тэтгэвэр тогтоогдох эрх үүсэх хүртэл нь нийт 107,590,943 (1614 нийт хоногийн) эмнэлгийн эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтанд Ажил олгогчоос 62,243,091.00 төгрөг, Нийгмийн даатгалын сангаас 45,347,852.00 төгрөгийн тэтгэмж олгосон.<br>● Эмнэлэг сувилахуйн болон тусгай мэргэжилтний хомсдолд орж ажлын байрны ажлын ачаалал эрс нэмэгдсэнтэй холбоотой Ерөнхий захирлын 2022 оны А/99 дугаар тушаалаар 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сувилахуйн болон тусгай мэргэжилтнүүдэд үндсэн цалингийн 15 хувийн нэмэгдлийг олгон ажиллаж байна.<br>● Хангамж, үйлчилгээний хэсгийн үйлчлэгчийн ажлын байранд ажиллах ажилтны хомсдол үүсч, батлагдсан орон тооноос нэн дутуу ажиллан нэг үйлчлэгчид ноогдох ажлын ачаалал эрс нэмэгдсэн тул Ерөнхий захирлын 2022 оны Б/313 дугаар тушаалаар 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үндсэн цалингийн 20%-ийн нэмэгдэл олгон ажиллаж байна.<br>● Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг бүрэн ханган ажилласан үйлчлэгч-13, жолооч-3, слесарь-3, шил угаагч-2, угаагч-2, ариутгагч-2, нярав-1, сувилагч-11, рентген |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | техникч-1, лаборант-1 нийт 40 ажилтнуудад Эрүүл мэндийн салбарын ажилтны баярын өдрийг ториолдуулан 2,000,000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. (Эмнэлгийн захирлын 2023 оны А/71, А/83 дугаар тушаал)<br>● Эрүүл мэндийн салбарын ажилтны баярын өдрөөр Эрүүл мэндийн яамны жуух бичгээр эмч-3, рентген техникч-3 сувилагч-2, цахим бүртгэл, лавлагааны ажилтан-3, инженер-1, эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч-1 нийт 13 ажилтан, Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан тэмдгээр эмч-4, сувилагч-ариутгагч-1 нийт 5 ажилтан, хамтран ажиллагч байгууллагын гарын бэлгээр нийт 20 ажилтныг тус тус шагнаж урамшуулсан.<br>● Эмнэлгийн дэргэдэх хүүхдийн цэцэрлэгт нийт 4 бүлэгт 98 эмнэлгийн ажилтны хүүхэд хүмүүжиж байна. |

ТАЙЛАН БИЧСЭН: ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБА
СУРГАЛТ, ГАДААД ХАРИЛЦААНЫ АЛБА
СУВИЛАХУЙН АЛБА